



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/164

Улаанбаатар хот

Сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгийн  
зүрхний эмгэгийн илрүүлэгт эмч нарын  
баг ажиллуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24 дэх заалт, 8.5 дахь хэсэг, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалт, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсэг, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгийн зүрхний эмгэгийн илрүүлгийн багт ажиллах хүүхдийн зүрх судлалын эмч нарын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгийн зүрхний эмгэгийн илрүүлэгт зохион байгуулах удирдамжийг хоёрдугаар, Сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгийн зүрхний эмгэгийн илрүүлэг хийх зүрх судлалын эмч нарын ажиллах хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгийн зүрхний эмгэгийн илрүүлгийг хавсралтаар батлагдсан удирдамж, хуваарь, аргачлалын дагуу чанартай гүйцэтгэхийг хүүхдийн зүрх судлалын эмч нарын багийн ахлагч (Т.Болормаа)-д, эмч нарын ажил үүргийн хуваарь, ажлын ачааллыг зохицуулж ажиллахыг Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүдийн дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгийг жил бүр удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийтийн Эрүүл мэндийн бодлогын газар (Л.Баттөр)-т, хүүхдийн зүрх судлалын эмч нарын багийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Р.Гантуяа)-т, эрт илрүүлэг үзлэгийн цахим программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангаж, эмч нарт холбогдох сургалтыг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 04 сарын 22 өдрийн 9/64 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгийн зүрхний эмгэгийн илрүүлгийн багт ажиллах зүрхний эмч нарын багийн бүрэлдэхүүн

Ахлагч:

Т.Болормаа,  
Эх, Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Хүүхдийн эмнэлэг хариуцсан дарга

Гишүүд:

Н.Баярмаа,  
Улсын гуравдугаар төв эмнэлгийн Зүрх судасны мэс заслын тасгийн хүүхдийн зүрхний судсан дотуурх мэс заслын эмч

Э.Наранцацрал,  
Эх, Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн, Зөвлөх поликлиникийн тасгийн эрхлэгч, хүүхдийн зүрх судас, холбогч эдийн эмгэг судлалын эмч

Б.Ундрал,  
Эх, Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Зүрх судас, холбогч эдийн эмгэг судлалын тасгийн эрхлэгч

Ж.Бат-Ундрах,  
Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Зүрх судас, холбогч эдийн эмгэг судлалын тасгийн эмч

Б.Батсуурь,  
Эх, Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Зүрх судас, холбогч эдийн эмгэг судлалын тасгийн эмч

Б.Бэхбат,  
Эх, Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Зүрх судас, холбогч эдийн эмгэг судлалын тасгийн эмч

Г.Хонгор,  
Эх, Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Зүрх судас, холбогч эдийн эмгэг судлалын тасгийн эмч

Т.Мөнхтулга,  
Эх, Нярай Эмэгтэйчүүдийн Үндэсний Төв-2 эмнэлгийн Зөвлөх поликлиникийн хүүхдийн зүрх судас, судсан дотуурх мэс заслын эмч

Б.Бямбажав,

Эх, Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн нярайн тасгийн эмч, Хүүхдийн зүрх судасны эмч

Т.Тэгшжаргал,

Эх, Нярай Эмэгтэйчүүдийн Үндэсний Төв-2 эмнэлгийн Дотрын нэгдсэн тасгийн зүрхний эмч, Хүүхдийн зүрх судлалын эмч

Н.Дарьсүрэн,

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн Хүүхдийн тэнхимийн багш, АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлгийн хүүхдийн эрчимт эмчилгээний эмч

А.Дэлгэрмөнх,

Төрийн Тусгай Албан Хаагчдын Нэгдсэн Эмнэлгийн Хүүхдийн тасгийн эмч, Хүүхдийн зүрх судлалын эмч

Ч.Халиун, Сонгинохайрхан Дүүргийн Нэгдсэн Эмнэлгийн Хүүхдийн тасгийн эмч, Хүүхдийн зүрх судлалын эмч

М.Мөнгөншагай,

Сонгинохайрхан Дүүргийн Нэгдсэн Эмнэлгийн Яаралтай тусламжийн тасгийн хүүхдийн эмч

Д.Номин,

Чингэлтэй Дүүргийн Нэгдсэн Эмнэлгийн Хүүхдийн тасгийн эмч, Хүүхдийн зүрх судлалын эмч

Д.Туяацэцэг,

Чингэлтэй Дүүргийн Нэгдсэн Эмнэлгийн Хүүхдийн тасгийн эмч, Хүүхдийн зүрх судлалын эмч

П.Нэргүй,

Багануур Дүүргийн Эрүүл Мэндийн Төвийн хүүхдийн эмч, Хүүхдийн зүрх судлалын эмч

С.Ванчиндорж,

Сүхбаатар Дүүргийн Эрүүл Тэндийн төвийн мэс заслын эмч, Хүүхдийн зүрхний мэс заслын эмч

Э.Энхтуул, Гурван гал эмнэлгийн хүүхдийн эмч, Хүүхдийн зүрх судлалын эмч

--oOo--

## Сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгийн зүрхний эмгэгийн илрүүлгийг зохион байгуулах удирдамж

### Нэг. Нийтлэг үндэслэл.

Монгол Улсын хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд амьсгал, хоол боловсруулах, зүрх-судасны тогтолцооны өвчин эхний 3 байрыг эзэлж, харин нас баралтын хувьд зүрх судасны эмгэгийн шалтгаант нас баралт сүүлийн 30 жил эхний байрыг эзэлсээр байна.

2023 оны байдлаар манай улсад 0-18 хүртэлх насны 1 сая 96 мянган хүүхэд байгаа бөгөөд нийт хүн амын 63.4 хувийг эзэлж байна. 18 хүртэлх насны хүүхдийн дунд зүрхний эмгэгийн эрт илрүүлэх, оношлох, улмаар эмчилгээнд хамруулах, уг эмгэгт хүргэдэг эрсдэлийг бууруулах эрүүл мэндийн боловсрол олгох зэрэг интервенцийг цэцэрлэг, сургууль, гэр бүлд чиглүүлэн хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байдаг.

Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад хүүхэд бүрийг сургуульд элсэх үед нь эрүүл мэндийн цогц үзлэг, оношилгоонд хамруулж, ялангуяа зүрхний эмгэгийг эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн байдаг байна. Харин манай улсын хувьд ерөнхий боловсролын сургуульд суралцагсдын сурлагын талаарх бүртгэл, мэдээлэл байдаг ч тэдний эрүүл мэндийн ерөнхий үзүүлэлт, өвчлөлийн талаарх нэгдсэн мэдээлэл огт бүрдээгүй байна.

Иймд сургуульд суурилсан эрт илрүүлэгийг зохион байгуулж, хүүхдийн зүрхний өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээг хийж, тэдний эрүүл мэндтэй холбоотой цахим мэдээллийг санг бүрдүүлэн эрүүл мэндийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

### Хоёр. Зорилго

Сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгээр хүүхдийн зүрхний өвчин эмгэг илрүүлэх үзлэгийг үе шаттай зохион байгуулж, оношилгоо, эмчилгээ, хяналтын цахим мэдээний санг бүрдүүлэх замаар хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах

### Гурав. Зүрхний эмгэгийн илрүүлгийн үе шатууд

3.1. Сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгийн зүрхний эмгэгийн илрүүлгийг Анхан Шатны Эрүүл Мэндийн Байгууллагатай хамтран зохион байгуулж, Зүрхний цахилгаан бичлэг хийж, дүгнэлт өгөх,

3.2. Зүрхний цахилгаан бичлэгийн дүгнэлтээр өөрчлөлттэй гарсан хүүхдийг зүрхний хэт авиан оношилгоонд Аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төв рүү илгээж зүрхний эмгэгийг илрүүлэх,

3.3. Зүрхний хэт авиан оношилгоогоор өвчин оношлогдсон тохиолдолд лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээж эмчилгээнд хамруулах, хяналтанд авах.

Дөрөв. Сургуульд суурилсан эрт илрүүлгийг зохион байгуулахад эрүүл мэндийн байгууллагын чиг үүрэг

4.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хүлээнэ:

4.1.1. Сургуульд суурилсан эрүүл мэндийн эрт илрүүлэг үзлэгийг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах;

4.1.2. Эрт илрүүлэг үзлэг хийх аргачлал, зааврыг олон улсын туршлага, нотолгоо, судалгаа, мэргэжлийн тэргүүлэх байгууллага, мэргэжлийн салбар зөвлөлийн саналыг үндэслэн боловсруулах;

4.1.3. Эрт илрүүлгийн эмнэлзүйн заавар, удирдамжийг шаардлагатай тохиолдолд шинэчлэх;

4.1.4. Эрт илрүүлэг үзлэгт шаардагдах хүний нөөц, багаж, тоног төхөөрөмжөөр эрүүл мэндийн байгууллагуудыг үе шаттай хангах;

4.1.4. Эрт илрүүлгийн үйл ажиллагааны зохион байгуулалт, үр дүн, зардлын үр ашиг, эрүүл мэндийн салбарт үзүүлэх үр нөлөөг үнэлэх, судлах, хэрэгжилтэд хяналт тавих;

4.1.5. Эрт илрүүлгийн цахим бүртгэлийн мэдээний сан байгуулах, хадгалах, баяжуулах, ашиглах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, цахим системийг эрүүл мэндийн салбарын бусад цахим платформуудтай холбох.

4.2. Лавлагаа шатлалын эмнэлэг, төвүүд дараах чиг үүргийг хүлээнэ:

4.2.1. Эрт илрүүлгийн тусламж, үйлчилгээний эмнэлзүйн заавар, удирдамжийг ашиглан сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтад эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сургуулийн эмч, сургуулийн эмч, ажилтнуудыг хамруулах ажлыг зохион байгуулах;

4.2.2. Онош тодруулахаар илгээсэн хүүхдийг хүлээн авч, оношийг баталгаажуулах, эмчилгээ, хяналтын зааварчилгаа өгөх, шаардлагатай тохиолдолд мэргэшсэн эмчийн шууд хяналтад авах, эргэн мэдээлэх;

4.2.3. Эрт илрүүлгийн үйл ажиллагаанд хамтран ажиллаж буй хүүхдийн зүрхний эмч нарын ажил үүргийн хуваарь, ажлын ачааллыг зохицуулах;

4.3 Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв дараах чиг үүргийг хүлээнэ:

4.3.1. Эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг үнэлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

4.3.2. Эрт илрүүлгийн эмнэлзүйн заавар, удирдамж, гарын авлага, сургалтын хөтөлбөр боловсруулахад санал өгөх;

4.3.3. Эрт илрүүлгийн талаарх мэдээллийг сурталчлах нэгдсэн загварыг гаргаж, эрүүл мэндийн байгууллагуудад түгээх, байгууллагын фэйж хуудас,—цахим хуудсанд байршуулах;

4.3.4. Эрт илрүүлгийн ач холбогдлыг таниулж, хамрагдахыг уриалсан мэдээллийг шинжлэх ухааны нотолгоонд түшиглэн хүн бүрд ойлгомжтой байхаар боловсруулж, мэдээллийн бүх төрлийн сувгаар хүртээмжтэй түгээх.

4.4 Эрүүл мэндийн хөгжлийн төв дараах чиг үүргийг хүлээнэ:

4.4.1. Эрт илрүүлгийг зохион байгуулахад шаардагдах хүний нөөцийг бүрдүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сургуулийн эмч, ажилтнуудыг чадавхжуулах богино хугацааны сургалтыг улсын хэмжээнд үе шаттай зохион байгуулах;

4.4.2. Эмнэлзүйн заавар, удирдамж болон сургалтад ашиглах хичээл, гарын авлагын нэгдсэн санг үүсгэн, байгууллагын цахим хуудсанд байршуулах;

4.4.3. Эрт илрүүлгийн тоо мэдээг цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, мэдээлэх, чанарын хяналт тавих;

4.4.4. Эрт илрүүлгийн эрүүл мэндийн лавлагаа гаргах нэгдсэн цахим программ хангамжийг хариуцан, шуурхай, тасралтгүй байдлыг ханган ажиллах;

4.4.5. Цахим системийн сургалтыг эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сургуулийн эмч, ажилтанд зохион байгуулж, тасралтгүй, тогтмол хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах.

4.5.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар дараах чиг үүргийг хүлээнэ:

4.5.1. Эрт илрүүлэгт ашиглагдах эмнэлгийн хэрэгслийн нэгдсэн худалдан авалтыг зохион байгуулах, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх.

4.6.Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар дараах чиг үүргийг хүлээнэ:

4.6.1. Эрт илрүүлэгт шаардлагатай санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас чанар, төлбөрийн хяналтын шалгуурын дагуу санхүүжүүлэх;

4.6.2. Эрүүл мэндийн байгууллагын шатлал тус бүрээр санхүүжилтийг тооцож, жил бүрийн төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэлд тусгахаар санал боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хуульд заасан хугацаанд хүргүүлэх;

4.6.3. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран олон нийтэд сурталчлах, халдварт болон халдварт бус өвчлөлийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад эрт илрүүлгийн ач холбогдлын талаар эрүүл мэндийн байгууллага болон даатгуулагчдад зориулсан зөвлөгөө, мэдээллийн үйл ажиллагаа зохион байгуулах;

4.6.4. Эрт илрүүлгийн санхүүжилтийн талаарх үр дүн, үр ашиг, үр нөлөөний талаарх судалгаа, тооцооллыг хийж, хяналт тавих.

4.7.Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар дараах чиг үүрэг хүлээнэ:

4.7.1. Эрт илрүүлгийг зохион байгуулахад харьяалах нутаг дэвсгэрийн хүүхдүүдийг хамруулах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах;

4.7.2. Эрт илрүүлгийг үндсэн тусламж, үйлчилгээний хүртээмж, оношилгоо эмчилгээний чанар, аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр зохион байгуулах;

4.7.3. Эрт илрүүлгийн мэдээ, мэдээллийн шуурхай, үнэн зөв байдлыг хангаж, тайланг хүлээн авч нэгтгэн, эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргэх;

4.7.4. Эрт илрүүлэгт шаардагдах эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл болон бүртгэлийн маягт, цахим программ, хүний нөөцийн хангамж, сургалтын хэрэгцээнд үнэлгээ хийж, жил бүрийн төсөвт суулгах шаардлагатай зардлыг тооцон орон нутгийн болон эрүүл мэндийн салбарын төсвийн төсөлд тусгах саналыг боловсруулж эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

4.7.5. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага, дүүргийн эрүүл мэндийн төвийг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, удирдаж, хяналт тавьж ажиллах.

4.8. Дүүргийн Эрүүл мэндийн төв дараах чиг үүрэг хүлээнэ:

4.8.1. Зүрхний эмгэг илрүүлэг үзлэгийн үе шатуудад хийгдэх зүрхний цахилгаан бичлэг, зүрхний хэт авиан оношилгоог хийж, дүгнэлт өгөх үйл ажиллагаануудыг тусгасан гэрээг хүүхдийн зүрхний эмч нарын багтай байгуулж, хамтран ажиллах;

4.8.2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг нэгдсэн зохион байгуулалт удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах;

4.8.3. Гэрээний хэрэгжилтийг хангуулж, хүүхдийн зүрхний эмч нарыг үйл ажиллагааны гүйцэтгэлээр нь цалинжуулж ажиллах.

4.9. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага дараах чиг үүрэг хүлээнэ:

4.9.1. Харьяа нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдад эрт илрүүлэг үзлэг хийх багийг ахалж, зохион байгуулна;

4.9.2. Аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төв, хүүхдийн зүрхний эмч нартай гурвалсан гэрээ байгуулж, эрт илрүүлгийн зүрхний үзлэгийн I үе шат болох зүрхний цахилгаан бичлэгийг хийх, хүүхдийн зүрхний эмч нартай хамтран зүрхний цахилгаан бичлэгт дүгнэлт өгөхөд оролцох;

4.9.3. Зүрхний цахилгаан бичлэгт өөрчлөлт илэрсэн II шатны илрүүлэгт хамрагдах шаардлагатай хүүхдийн мэдээллийг гаргаж нэгтгэх, эргэн мэдээлж, үзлэгийг дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулах;

4.9.4. Эрт илрүүлгийн үр дүнд зүрхний эмгэг илэрсэн, анхан шатны Эрүүл мэндийн байгууллагын хяналтад байх шаардлагатай хүүхдийг хяналтад авч, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх.

4.10 Хүүхдийн зүрх судлалын эмч нарын үүрэг:

4.10.1 Зүрхний эмгэгийн илрүүлэгт хамрагдсан хүүхдийн мэдээллийг цахим бүртгэлд оруулах чадварт суралцсан байх;

4.10.2 Төлөвлөсөн хугацаанд хуваарийн дагуу зүрхний цахилгаан бичлэгийг үнэн зөв уншиж, дүгнэлтийг цахим системд оруулах;

4.10.3 Аймгийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран зүрхний хэт авиан оношилгоо, үзлэгийг хийж гүйцэтгэн, дүгнэлтийг цахим системд оруулах;

4.10.4 Зүрхний хэт авиан оношилгоо, үзлэгт хамрагдсан хүүхдэд хяналтын талаар заавар, зөвлөгөө өгч ажиллах;

4.10.5 Дүүргийн Эрүүл мэндийн төв, Аймгийн нэгдсэн эмнэлэг, анхан шатны эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулж, батлагдсан хуваарийн дагуу үзлэг, оношилгоог хийж, цахим программд хадгалагдсан Зүрхний цахилгаан бичлэгийг ажлын 3-5 хоногийн дотор зааврын дагуу уншиж, дүгнэлт өгнө.

4.10.6 Зүрхний эмгэгтэй хүүхдийн эмчилгээ, хяналтын талаар мэдээлэл, зөвлөгөөг өгнө.

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 04  
сарын 01 өдрийн 461 дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт

Сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгийн зүрхний илрүүлэгт хамтран ажиллах  
хүүхдийн зүрх судлалын эмч нарын бүрэлдэхүүн, ажиллах хуваарь


А.Улаанбаатар хотын дүүргүүд

| №  | Дүүргийн нэр       | Зүрхний цахилгаан бичлэг<br>уншиж, дүгнэлт өгөх эмч нарын<br>нэрс | Зүрхний хэт авиан<br>оношилгоо хийж, дүгнэлт<br>өгөх эмч нарын нэрс |
|----|--------------------|-------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------|
| 1  | Чингэлтэй          | Т.Болормаа                                                        | Т.Болормаа                                                          |
| 2  |                    | Б.Батсуурь                                                        |                                                                     |
| 3  | Хан-уул            | Г.Хонгор                                                          | Т.Мөнхтулга                                                         |
| 4  |                    | Т.Тэгшжаргал                                                      |                                                                     |
| 5  |                    | М.Мөнгөншагай                                                     |                                                                     |
| 6  |                    | Т.Мөнхтулга                                                       |                                                                     |
| 7  | Баянгол            | Э.Наранцацрал                                                     | Э.Наранцацрал                                                       |
| 8  |                    | Д.Туяацэцэг                                                       |                                                                     |
| 9  | Сонгино<br>хайрхан | Н.Баярмаа                                                         | Н.Баярмаа                                                           |
| 10 |                    | Ч.Халиун                                                          |                                                                     |
| 11 | Сүхбаатар          | А.Дэлгэрмөнх                                                      | Б.Ундрал                                                            |
| 12 |                    | Б.Бямбажав                                                        |                                                                     |
| 13 | Баянзүрх           | Ж.Бат-Ундрах                                                      | Ж.Бат-Ундрах                                                        |
| 14 |                    | Б.Бэхбат                                                          |                                                                     |
| 15 |                    | Н.Дарьсүрэн                                                       |                                                                     |
| 16 |                    | Д.Номин                                                           |                                                                     |
| 17 | Багануур           | П.Нэргүй                                                          | Г.Хонгор                                                            |
| 18 | Багахангай         | Б.Баярмаа                                                         |                                                                     |
| 19 | Налайх             |                                                                   |                                                                     |

Б.Орон нутаг – Аймгууд

| №  | Аймгийн нэр      | Зүрхний цахилгаан бичлэг<br>уншиж, дүгнэлт өгөх эмч<br>нарын нэрс | Зүрхний хэт авиан<br>оношилгоо хийж, дүгнэлт<br>өгөх эмч нарын нэрс |
|----|------------------|-------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------|
| 1  | Архангай         | Ж.Бат-Ундрах,<br>Д.Номин                                          | Ж.Бат-Ундрах,<br>Т.Болормаа                                         |
| 2  | Баян-Өлгий аймаг | Э.Энхтуул,<br>Т.Болормаа                                          | Б.Ундрал                                                            |
| 3  | Баянхонгор аймаг | Т.Мөнхтулга                                                       | Н.Баярмаа                                                           |
| 4  | Булган аймаг     | Б.Батсуурь,<br>П.Нэргүй                                           | Э.Наранцацрал                                                       |
| 5  | Говь-Алтай аймаг | Э.Наранцацрал<br>Б.Баярмаа                                        | Т.Болормаа                                                          |
| 6  | Говьсүмбэр аймаг | Э.Энхтуул,<br>Т.Болормаа                                          | Ж.Бат-Ундрах,<br>Б.Ундрал                                           |
| 7  | Дархан-Уул аймаг | Б.Ундрал,<br>П.Нэргүй                                             | Э.Наранцацрал                                                       |
| 8  | Дорноговь аймаг  | Э.Наранцацрал,<br>Т.Тэгшжаргал                                    | Б.Ундрал                                                            |
| 9  | Дорнод аймаг     | Б.Батсуурь,<br>Б.Баярмаа                                          | Т.Болормаа                                                          |
| 10 | Дундговь         | М.Мөнгөншагай                                                     | Н.Баярмаа                                                           |
| 11 | Завхан аймаг     | Д.Туяацэцэг                                                       | Н.Баярмаа                                                           |
| 12 | Орхон аймаг      | Ж.Бат-Ундрах,<br>Д.Туяацэцэг                                      | Э.Наранцацрал                                                       |
| 13 | Өвөрхангай аймаг | Э.Наранцацрал,<br>Б.Баярмаа                                       | Ж.Бат-Ундрах,<br>Э.Наранцацрал                                      |
| 14 | Өмнөговь аймаг   | Н.Дарьсүрэн                                                       | Н.Баярмаа                                                           |
| 15 | Сүхбаатар аймаг  | Г.Хонгор                                                          | Т.Болормаа                                                          |
| 16 | Сэлэнгэ аймаг    | Н.Баярмаа,<br>Б.Бэхбат                                            | Э.Наранцацрал                                                       |
| 17 | Төв аймаг        | Ж.Бат-Ундрах,<br>Ч.Халиун                                         | Т.Болормаа                                                          |
| 18 | Увс аймаг        | Б.Бямбажав                                                        | Н.Баярмаа                                                           |
| 19 | Ховд аймаг       | Н.Баярмаа,<br>Б.Баярмаа                                           | Б.Ундрал                                                            |
| 20 | Хөвсгөл аймаг    | Н.Баярмаа,<br>С.Ванчиндорж                                        | Ж.Бат-Ундрах,<br>Н.Баярмаа                                          |
| 21 | Хэнтий аймаг     | Э.Наранцацрал,<br>А.Дэлгэрмөнх                                    | Т.Болормаа                                                          |

# Зүрхний эмгэгийн илрүүлэг, үзлэгийн зураглал



ЭМЯ- Эрүүл мэндийн яам  
 НЭМГ- Нийслэлийн эрүүл мэндийн газар  
 АЭМГ- Аймгийн эрүүл мэндийн газар  
 ДЭМТ- Дүүргийн эрүүл мэндийн төв  
 АШЭМБ- Анхан шатны эрүүл мэндийн байгууллага  
 ЕБС- Ерөнхий боловсролын сургууль